



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2023.12.15 № 0319145  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Гомдол хянасан тухай

“МИАТ” ТӨХК-Д

СЭЖ Н.УУС  
ХУХ А.Амарсүхбаяр

Халварын үйлчилгээ  
Сүрьеэ үйлдвэр  
арла Дамшита авч  
ЭМБ 02/19

Танай байгууллагаас зарласан МИАТ/202310108 дугаартай “Зорчигчийн үйлчилгээний нэг удаагийн бараа бүтээгдэхүүн” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 3 дугаар багцад оролцсон “Кэй жи платформ” ХХК-ийн гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Кэй жи платформ” ХХК-ийн гомдолд тус тендер шалгаруулалтын 3 дугаар багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн Стандарт хэмжил зүйн газраас олгосон УБД0001038 бүртгэлийн дугаартай “Тохирлын гэрчилгээ” нь хуурамч байх магадлалтай тул уг асуудлыг хянан үзэхийг, мөн тус тендер шалгаруулалтад санал ирүүлсэн бүх аж ахуйн нэгжүүдийн тендер нь тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.6.8-д “Эрүүл ахуйн шаардлага хангасныг нотлох Үндэсний стандартчилал хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ эсхүл Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийн аль нэгийг бүтээгдэхүүн тус бүр дээр ирүүлнэ” гэж заасан шалгуурыг хангаж байгаа эсэх, ирүүлсэн лабораторийн бичиг болон тохирлын гэрчилгээ нь хуурамч эсэхийг шалгуулахыг хүссэн байна.

“Кэй жи платформ” ХХК-ийн гомдолд дурдсаны дагуу тус тендер шалгаруулалтын 3 дугаар багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.6.8-д “Эрүүл ахуйн шаардлага хангасныг нотлох Үндэсний стандартчилал хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ эсвэл Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийн аль нэгийг бүтээгдэхүүн тус бүр дээр ирүүлнэ.” гэж заасан байна.

“Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн тендерт Стандартчилал, хэмжил зүйн газраас тус компанид 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр олгосон “УБД0001038” дугаартай “нэг удаагийн хүнс хадгалах алюминийн сав” бүтээгдэхүүний “Тохирлын гэрчилгээ”-г ирүүлсэн байна.

“Кэй жи платформ” ХХК-ийн гомдолд “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн дээрх тохирлын гэрчилгээ нь хуурамч байх магадлалтай талаар дурдсан байх тул тус компанийн тендерт ирүүлсэн “УБД0001038” дугаартай “Тохирлын гэрчилгээ”-ний хуурамч эсэхийг холбогдох байгууллагаас тодруулж, тендерийн баримт бичигт заасан дээрх шаардлагад нийцэх эсэхийг дахин нягтлан үзэх нь зүйтэй байна.

Хэрэв “Грандавто ланд” ХХК нь худал мэдээлэл бүхий тендер бэлтгэн тендерт оролцсон бол хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн худалдан авах ажиллагааны улсын байцаагчид тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах саналыг ирүүлнэ үү.

Харин хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “... захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана.”, Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын 4.1-д тендерт оролцогч үндэслэл бүхий гомдол гаргана гэж тус тус заасан тул гомдолд дурдсан тендерт оролцсон бүх аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн лабораторийн бичиг болон тохирлын гэрчилгээний хуурамч эсэх, тендерийн баримт бичигт заасан дээрх шаардлагад нийцэж байгаа эсэх асуудлыг хянан үзэх боломжгүй байна.


Хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн тус тендер шалгаруулалтын 3 дугаар багцад гэрээ байгуулах эрх олгосон 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/2507 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Кэй жи платформ” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the text 'МОНГОЛ УЛСЫН ХАВГАГАГЧИЙН АЖЛАГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА' (State Agency for Consumer Protection of Mongolia) and 'ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА' (State Agency Director) in Mongolian. The signature is written in a cursive style.

Ж.ГАНБАТ